



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/17

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.10, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.6, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.11, 26 дугаар зүйлийн 26.3, 26.1, 26.1.3, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ын хавсралт, Хэнтий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Байгууллагын санхүүгийн бүртгэл тайлангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, санхүүгийн тайлангын аудитаар "хязгаарлалттай" санал дүгнэлт авч аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/14 дүгээр захирамжаар сануулах сахилгын шийтгэл, Төсвийн хөрөнгийг аривлан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчил гаргасан нь аймгийн Аудитын газрын 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн албан шаардлагаар тогтоогдож аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар сануулах сахилгын шийтгэл, тус тус хүлээж сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн 5.2.2, 5.4.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн болон аймгийн Аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн нийцлийн аудитаар 7, 8, 9, 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн гүйцэтгэл, 5 саяаас дээш орлого, зарлагын гүйлгээ, худалдан авалтын мэдээг тус тус хангалтгүй байршуулсан, хугацааг баримтлаагүй зөрчил гаргасан нь тогтоогдсон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Г.Энхбаярыг

2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулсугай.

Хоёр. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Ц.Ганчимэг

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Ж.Саруултөгс

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Ц.Цэрэндорж

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн

Гурав. Г.Энхбаяртай холбогдох тооцоог хийж дуусгахыг БОАЖГ-ын ня-бо /Л.Түмэнжаргал/-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА